

ДУНДГОВЬ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР



**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН
ДҮРМИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021 ОН



БАТЛАВ
 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
 ДАРГАА *[Signature]*
 М.НАРАНБАДРАХ
 3НОАМ/33653
 2021 оны 02 сарын 02

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 02 дугаар сарын 09 өдөр

Сайнцагаан сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Хариуцах эзэн	Хугацаа
1	Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс бэлэг, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусад хангамж эдлэхгүй байх.	Иргэн хуулийн итгээдэд давуу байдал олгохгүй байх. Бусдаас шан харамж авахгүй байх.	Дотоод хяналтын баг	I-IV улирал
2	Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх.	Иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчлэх.	Нийт албан хаагчид	I-IV улирал
3	Хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх.	Санхүүгийн ажилтны хамаарал бүхий этгээдийн судалгааг гаргаж мэдүүлэх.	Дотоод хяналтын баг	I-IV улирал
4	Албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх.	Зүй бус үйлдэл гаргаагүй байх.	Дотоод хяналтын баг	I-IV улирал
5	Жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх.	Эрх тэгш байх.	Дотоод хяналтын баг	I-IV улирал
6	Төрт ёс, түүх, соёлын өв уламжлалаас суралцах, Монголын ард түмний соёл, зан үйлийг хүндэтгэх.	Түүхт өв уламжлалаа бие даан судлах. Үндэсний спортыг хөгжүүлэх.	Нийт албан хаагчид	I-IV улирал
7	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй зөлдөг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, алтаварлалгүйгээр хөнгөн шугуйтай хүргэх.	Иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчлэх	Нийт албан хаагчид	I-IV улирал

8	Төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх.	Ёс зүйн зөрчил гаргаагүй байх.	Нийт албан хаагчид	I-IV улирал
9	Албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согнууруулах ундаа хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих.	Байгууллагын соёл, дэг журмыг мөрдөж ажиллах.	Нийт албан хаагчид	I-IV улирал
10	Төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, хууль ёсны үйл ажиллагааг үл эсэргүүцэх, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх.	Бодлого, хууль ёсны үйл ажиллагааг мөрдөж ажиллах.	Нийт албан хаагчид	I-IV улирал
11	Албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх.	Ёс зүйн зөрчил гаргаагүй байх.	Нийт албан хаагчид	I-IV улирал
12	Төрийн алба хаах хугацаанд улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх.	Улс төрөөс ангид байх.	Нийт албан хаагчид	I-IV улирал
13	Төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахгүй байх.	Зөрчил гаргаагүй байх.	Нийт албан хаагчид	I-IV улирал
14	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх.	Төвийг сахиж ажилласан байна.	Нийт албан хаагчид	I-IV улирал
15	Удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх.	Байгууллагын соёлыг тогтоох.	М.Наранбадрах /дарга/	I-IV улирал
16	Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.	Төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлсэн байна.	Б.Дашбилэг /ахлах мэргэжилтэн/	I-IV улирал

БОЛОВСРУУЛСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б. Дашбилэг